

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН**  
**2015 ОНЫ ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН**  
*(2015 оны 11 сарын 24-ний байдлаар)*

Иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг бичгээр, цахимаар, санал хүсэлтийн хайрцаг, утсаар болон албадын дарга нар биечлэн хүлээн авч шийдвэрлэж байна.

**1. Бичгээр** 2015 оны 11 сарын 24-ний байдлаар нийт 1078 өргөдөл ирснээс хариу өгсөн 1027, хугацаа болоогүй 48, 3 өргөдөл шийдвэрлэх хугацаа хоцорсон байна. Нийт ирсэн өргөдлөөс Гематологийн багшийн талаар, төвийн эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн шалгалт болон жижүүр, постын харилцаа, хандлагын талаар гаргасан 3 гомдлыг хүлээн авч шийдвэрлэж хариу өгсөн байна

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг албадаар нь гаргавал:

Албаны нэр	Нийт ирсэн өргөдөл	Хариу өгөгдсөн	Хугацаа болоогүй	Хугацаа хоцорч	
				хариу өгсөн	хариу өгөөгүй
ЗААА	331	302	29	34	
МТЭТТА	1	1			
СТСМА	3	3		1	
ЭЗА	7	5	1		1
ЭМХА	736	716	18	85	2
<b>Нийт</b>	<b>1078</b>	<b>1027</b>	<b>48</b>	<b>120</b>	<b>3</b>

- ЭМ-ний зөвшөөрөл олгох, сунгах, сольж өгөх-380(35.2%)
- Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн шалгалтанд оруулж өгөхийг хүссэн -51(4,7 %)
- Шалгалтанд тэнцсэн тодорхойлолт хүссэн -57(5,3%)
- Шалгалтын материалыг дахин шалгаж өгөхийг хүссэн-62( 5,8%)
- Шалгалтанд тэнцүүлж өгөх-27(2,5%)
- Байранд орох асуудлаар-140/(1.3%)
- Архивын лавлагаа хуулбар хүссэн (зөвшөөрөл, зэрэг, магадлан, эм г.м )-109(10.1%)
- Резидентийн сургалтанд суралцуулж өгөх, хуваарь солих, үнэмлэх олгож өгөхийг хүсэх - 78(7.2%)
- Төрийн сангаар мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдах болон түүнтэй холбогдох хүсэлт -40 (3.7%)
- Ажилд орох болон чөлөөлж өгөхийг хүссэн-15(1.4%)
- Тэтгэвэр, тэтгэмж, илүү цагийн мөнгөтэй холбоотой-16(1.5%)
- Чөлөө олгож өгөхийг хүссэн-14 (1.3%)
- Ээлжийн амралт олгож өгөхийг хүсэх болон илүү цаг ажилласан-15(1.4%)
- Эмнэлгийн мэргэжилтний зэргийн шалгалт, үнэмлэх олгож өгөхийг хүссэн-15(1.4%)
- Бусад 59(5.5%)

**Цаашид:** Хугацаа хэтрэлтийн байдлыг үзэхэд ЭМХТ, ЭМСЯ-тай харилцан ярилцаж шийдвэрлэх шаардлагатай өргөдлүүд байлаа. Үүнийг цаг тухай бүрд нь сунгалт хийлгэж байх

**2. Цахимаар:** 2015 онд төвийн [www.chd.mohs.mn](http://www.chd.mohs.mn) вэб хуудасны санал, хүсэлтийн булангаар нийт 52 хүсэлт ирсэнийг тухай бүрд нь шалгаж холбогдох алба, мэргэжилтнүүдээс хариуг авч утсаар мэдэгдлээ. Ирсэн хүсэлтийн 90 гаруй хувь нь Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн албаны үйл ажиллагаатай холбоо бүхий асуудлаар хандсан байлаа. Ирсэн санал, хүсэлтийн шийдвэрлэлт болон хэтрэлтийн талаар 7 хоногийн тайланд бичиж тайлагнаж байна.

**3.Санал, хүсэлтийн хайрцагар:** Нийт 7 хүнээс санал ирсэн нь төвийн эмнэлгийн мэргэжилтнүүдийн харилцаа, хандлагыг сайжруулах, шалгалтын босго оноог багасгаж өгөх,

эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн албанд тогтмол утас ажиллуулж өгөх талаар санал хүсэлтээ ирүүлсэн байна.


Дээрх ирүүлсэн санал, гомдлыг 7 хоногийн шуурхай хурал дээр тайлагнадаг бөгөөд тухайн асуудал хариуцсан ажилтан, албан хаагчид болон албадын дарга нарт ажил хэргээ сайжруулж ажиллах талаар тухай бүрт нь үүрэг даалгавар өгөн ажиллаж байна.

**4. Утсаар:** Төвийн 320633 утсаар нийт 40 асуултын 95 орчим хувь нь Төгсөлтийн дараах сургалтын холбогдолтой цахим бүртгэл, шалгалтын тест, резидентийн сургалт болон резидентэд элсэх, зөвшөөрлийн гэрчилгээ удаан гарч байгаа болон цаасаар тестийн шалгалтыг авч өгөхийг хүссэн хүсэлтүүд байлаа. Тухай бүрд нь холбогдох алба, мэргэжилтнүүдээс хариуг авч 7 хоногийн мэдээнд хавсралтаар танилцуулагдаж байна

Төвийн хэмжээнд эхний хагас жилийн байдлаар өргөдөл, гомдол хүлээж авсан байдлыг графикаар үзүүлбэл:

Төвийн хэмжээнд өргөдөл, гомдлыг хүлээж авсан байдлаар  
графикаар харуулбал

(2015 оны 11 сарын 24-ний байдлаар)



#### ДҮГНЭЛТ:

Өргөдлийн 11.13 % нь хугацаа хэтэрч шийдвэрлэсэн, 0.28 % огт шийдвэрлэгдээгүй өргөдөл байна.

Нийт ирсэн өргөдлийн 68.3 хувь нь Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн албаны үйл ажиллагаатай холбоотой өргөдөл эзэлж байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал харьцангуй сайжирсан.

Дийлэнх тодорхойлолт авч буй эмнэлгийн мэргэжилтнүүд нь шинээр ажилд орохоор ажлын байр нь хүлээгдэж байгаа, мөн мэргэжлийн хяналтын газрын шалгалт ирсэн, зарим эмнэлгүүд зөвшөөрлийн хугацаа нь дууссан тохиолдолд сунгалт хийгдээгүй бол түр болон бүр ажлаас нь чөлөөлөх зэрэг асуудлууд гарч байгаатай холбогдуулан албан тодорхойлолт хүсч ирж байна.